



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 4/499

Мандалговь

“Зохиомол саадын зурвас” тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30.1.17, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 зүйлийн 17.1.1, Батлан хамгаалахын сайд аймгийн Засаг даргатай 2021 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний ажил үйлчилгээ 5.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 16 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсад орчин цагийн шинэ үеийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд тус аймагт байрлалтай Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 278 дугаар байгууламжийн бий болсон спортын цогцолборын нээлтийн “Зохиомол саадын зурвас” тэмцээнд шаардагдах хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2. Тэмцээнд шаардагдах 1,000,000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат) нягтлан бодогч (М.Янжиндолгор)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

431210626

Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29 - ны өдрийн 11 дугаар захирамж хавсралт

ЗОХИОМОЛ СААДЫН ЗУРВАС ТЭМЦЭЭНИЙ ШАГНАЛ

№	Үйл ажиллагааны чиглэл	Нэг бүрийн үнэ	Тоо хэмжээ	Нийт
1	Тэмцээний I байр	450,000	1	450,000
2	Тэмцээний II байр	300,000	1	300,000
3	Тэмцээний III байр	150,000	1	150,000
4	Шүүгчийн зардал	100,000	1	100,000
БҮГД			1,000,000 төгрөг	